

**ОРГАНИК ЗӨГИЙН АЖ АХУЙД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД*****Нэг. Нийтлэг үндэслэл***

1.1. Органик зөгийг өсгөх, үржүүлэх, тэжээх, эрүүл мэндийг нь хамгаалах, зөгийн бал, лав, цэцгийн тоосонцрыг органик тэмдэг, тэмдэглэгээтэйгээр зах зээлд нийлүүлэхэд энэхүү журмыг баримтална.

***Хоёр. Зөгийн маллагаа, зөгийн суурийн зохион байгуулалт***

2.1. Зөгийн хоол тэжээлд хүрэлцэхүйц хэмжээний балт, тоост ургамал, усны эх үүсвэртэй, зөгийн сууриас 3 км-ын тойрог дотор орших органик газар тариалангийн газар, атаршсан талбай, эсхүл байгалийн бэлчээрт зөгийг бэлчээнэ.

2.2. 5 км-ын зайд органик бус тариалангийн талбай эсхүл бохирдлын эрсдэл өндөртэй (суурин газар, үйлдвэрийн болон уул уурхайн бүс, хурдны зам, хогийн цэг гэх мэт) газар байгаа тохиолдолд органик зөгийг суурилах, бэлчээхийг хориглоно.

2.3. Зөгийг байгальд бэлчээх үед уугуул нутгийн шавьжны бүлэг зүйлтэй нийцэж буй эсэх, аюулгүй байдал, зэрлэг ургамлын тоос хүртээх шаардлага зэргийг харгалзан үзнэ.

2.4. Зөгийн суурийн байршил, бэлчээр, отрын бэлчээр, тэжээллэг, зөгийн өвчний түүх, эмчилгээ, үр дүн, зөгийг тусгаарласан эсэх, зөгийн балыг хурааж авсан талаарх бүртгэлийг тогтмол хөтөлж, баталгаажуулна.

2.5. Зөгийн бүл нь тухайн орон нутгийн нөхцөлд дасан зохицож, амьдрах чадвартай, өвчин эсэргүүцэх, нөхөн үржих чадвар сайтай байна.

2.6. Зөгийг бүлээр нь органик үйлдвэрлэлд шилжүүлнэ.

2.7. Хэрэв бүртгэлтэй органик зөгийн аж ахуй байгаа тохиолдолд гаднаас авчирч буй зөгийг органик аж ахуйгаас нийлүүлнэ.

2.8. Зөгийн үүрийг байгаль орчинд ээлтэй, зөгийн бүтээгдэхүүнийг бохирдуулах эрсдэлгүй, байгалийн гаралтай материалаар хийнэ. Хоруу чанартай материал ашиглахыг хориглоно.

2.9. Зөгийн арчилгаа, маллагаанд хориглосон бодис ашиглаагүй, зөгийн лав бохирдох эрсдэл байхгүй тохиолдолд шилжилтийн хугацаанд зөгийн лавыг органик лаваар солих шаардлагагүй бөгөөд бусад тохиолдолд зөгийн лавыг органик лаваар солино. Хэрвээ бүх лавыг нэг жилийн хугацаанд солих боломжгүй тохиолдолд лавыг бүрэн солих хугацааг харгалзан шилжилтийн хугацааг сунгана.

2.10. Зөгийн сэмжийг 2 жил тутам тогтмол шинэчлэнэ.

2.11. Эх зөгийн далавчийг тайрах мэтээр зөгийг зэрэмдэглэхийг хориглоно.

2.12. Эх зөгийг зохиомлоор хээлтүүлж болно.

***Гурав. Зөгийн суурийн ариутгал, халдваргүйтгэл ба зөгийн эмчилгээ***

3.1. Дараах бодисоор зөгийн суурь, тоног төхөөрөмжийг тогтмол цэвэрлэж, ариутгана. Үүнд:

3.1.1. Сүүний болон шоргоолжны хүчил;

3.1.2. Охалик болон цууны хүчил;

3.1.3. Хүхэр;

3.1.4. Байгалийн гаралтай эфирын тос (жишээ нь: гаа, евакалипт, хамфор);

3.1.5. Туринжиенсис бацилус (*Bacillus thuringiensis*);

3.1.6. Усны уур, галын дөл болон каустик содоор үүрийг шууд ариутгах

3.2. Бохирдсон жааз, сэмж ба бусад материалыг устгана.

3.3. Зөгийн бүл болон өндөг дарагч эрэгчинд тогтмол үзлэг хийнэ.

3.4. Хэрвээ урьдчилан сэргийлэх арга хэмжээ үр дүнгүй бол ургамал, өвсний ханд, байгалийн гаралтай эмийн зүйл, ардын эмчилгээг ашиглан эмчилгээг хийнэ.

3.5. Зохиомол аргаар нийлэгжүүлсэн эм, эмийн зүйлийг хэрэглэсэн бол зөгийн бүтээгдэхүүнийг “органик” шошготойгоор зах зээлд нийлүүлэхийг хориглоно;

3.6. Зохиомол аргаар нийлэгжүүлсэн эм, эмийн зүйлийг хэрэглэсэн зөгийн бүлийг тусгаарлан, нэг жилийн хугацаанд шилжилтийн үед байлгана.

3.7. Varroa хорхойгоор (Varroa mites) өвчилсөн өндөг дарагч эр зөгийг устгана.

#### ***Дөрөв. Зөгийн тэжээл ба зөгийн аж ахуйн бүтээгдэхүүн***

4.1. Энэхүү журмын шаардлагыг нэг хүртэлх жилийн хугацаанд хангасан зөгийн аж ахуйн бүтээгдэхүүнийг органик шошготойгоор зах зээлд нийлүүлж болно.

4.2. Утаа, май ашиглахаас аль болох зайлсхийх ба утаа, май тавихад байгалийн гаралтай, энэ журмын шаардлагыг хангасан, зөвшөөрөгдсөн материалыг ашиглана.

4.3. Зөгийн бал хураахад химийн гаралтай синтетик зөгий дайжуулагчийг хэрэглэхийг хориглоно.

4.4. Зөгийн балыг хураах зорилгоор сархинагт байгаа зөгийг устгахыг хориглоно.

4.5. Өндөгтэй жаазнаас бал хураахыг хориглоно.

4.6. Зөгийн балыг хураах, зөгийн аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулахдаа дулааны хэмийг цельсийн 45<sup>0</sup>С хэмээс хэтрүүлэхгүй.

4.7. Өвөлжилтийн хугацаанд зөгийн бүлийг хангалттай хэмжээний зөгийн бал, цэцгийн тоосонцорын нөөцтэй үлдээнэ.

4.8. Нэмэлт тэжээлийг зөвхөн намрын сүүлчийн бал хураалтаас хаврын эхний балт болон тоост ургамал ургаж эхлэх үе хүртэл хэрэглэнэ. Энэ тохиолдолд нэмэлт тэжээл нь тухайн аж ахуйн эсхүл органик гаралтай зөгийн бал, органик элсэн чихэр байна.